Засгийн газрын Хэр... эрхлэх газрын даргын 2020 оны 100 тоот тушаалын 6 дугаар хавсралт

# ӨМЧИЙН ХЯНАЛТ,ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН Б.АДЪЯАГИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

## НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин биелэлт | | |
| 1 | 2 | 3 | 4 | | 5 | 6 | 7 |
| НЭГ. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙН ХҮРЭЭНД: | | | | | | | |
| ***1.1. Зорилт 1.*** *Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан бодлогын зорилтуудыг хангах ажиллана. /НХТЖҮЧ-4.1.1, НЗДҮАХ-3.1.1, ХАХТ-3.1.1.2, 3.1.1.3, 3.1.1.5, 3.1.4.3/* | | | | | | | |
| 1 | **Арга хэмжээ № 1.1.**<br>Арга хэмжээ: 1.1.1<br>Нийслэлийн төсвөөс санхүүжиж буй орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар болон орон нутгийн өмчит хаалттай хувьцаат компаний засаглалыг сайжруулж зохион байгуулалтын өөрчлөлт хийх<br>*НХТЖҮЧ-4.1.1, НЗДҮАХ-3.1.1.1, ХАХТ-3.1.1.2* | Байгууллагын тоо, хөрөнгийн хэмжээ | Нийслэлийн төсвөөс санхүүжиж байгаа хуулийн этгээдийн татан буулгах, статусын хэлбэрийг өөрчлөх ажлыг зохион байгуулна. | Нийслэлийн төсвөөс санхүүжиж байгаа хуулийн этгээдийн татан буулгах, статусын хэлбэрийг өөрчлөх асуудлыг НИТХ-аар хэлэлцүүлэн шийдвэрлүүлнэ. | **1. *Засаглалыг сайжруулах, статусийн хэлбэрийг өөрчлөх ажлын хүрээнд:***<br>➢ ***"Төв цэнгэлдэх хүрээлэн" ХХК***<br>НЗД-ын 2024 оны А/311 дүгээр захирамжаар "Төв цэнгэлдэх хүрээлэн" ХХК-ийн зарим асуудлыг шалгах ажлыг зохион байгуулах, холбогдох арга хэмжээ авах, шалгалтын үр дүнг үндэслэн цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан бөгөөд ажлын хэсгээс тус копманийн анхны хувьчилсан байдал, түүнтэй холбоотой шүүхийн шийдвэрүүд, улсын бүртгэл дэх хуулийн этгээдийн бүртгэл, төсвийн хөрөнгө оруулалт, бүртгэл хөтлөлт, одоогийн хөрөнгийн | 2024.01.01-2024.12.02 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байдал, ногдол ашиг хувиарлалт, газар, түүний өнөөгийн байдал зэрэг асуудлуудын хүрээнд хяналт шалгалтын ажлыг зохион байгуулсан.<br>Тус асуудлыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж, 2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 41 дүгээр тогтоолоор "Төв цэнгэлдэх хүрээлэн" ХХК-ийн хувийн өмчийн хувьцааны хууль ёсны өвлөгчид өвлөх эрхээсээ татгалзах хүсэлт гаргасныг үндэслэн өр төлбөрт суутган тооцох хэлцэл хийж, орон нутгийн өмчид 100 хувь шилжүүлэн авах, улсын бүртгэлд бүртгүүлэх арга хэмжээг зохион байгуулахыг Нийслэлийн Засаг даргад зөвшөөрсөн.<br>Энэхүү эрхийг шилжүүлсэнтэй холбогдуулан "Төв цэнгэлдэх хүрээлэн" ХХК-ийн 51 хувийн өвлөгч Н.Булганбаатартай холбогдох хэлэлцээрийг хийж, Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор 100% нийслэлийн өмчид шилжүүлэн, 100 хувийн хувьцаа эзэмшигчээр Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болгон өөрчилсөн.<br>1. *Хөрөнгө хүлээлцэх ажлын* | 2024.01.01-2024.12.02 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | <u>*хүрээнд:*</u><br><br>НЗД-ын 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн А/441 дүгээр захирамжаар байгуулагдсан "Төв цэнгэлдэх хүрээлэн" ХХК-ийн үл хөдлөх хөрөнгө, хөдлөх эд хөрөнгийг хүлээлцүүлэх ажлын хэсэг 2024 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр Төв цэнгэлдэх хүрээлэн ХХК-ийн байранд 10 цаг 15 минутад ажлыг эхлүүлж, 04 дүгээр сарын 21-ний өдөр дуусгав.<br><br>2. ***Татан буулгах ажлын хүрээнд**:*<br><br>➢ ***Улаанбаатар шинэ бүтээн байгуулалт ХХК***<br><br>Тус Компанийн хэрэгжүүлж байсан төслүүдийг дараах байгууллагуудад шилжүүлсэн. Үүнд:<br>✓ тулгуурт гүүрэн байгууламж бүхий багтаамж ихтэй шинэ төрлийн нийтийн тээврийн үйлчилгээ нэвтрүүлэх төслийн техникийн шийдэл, трассын чиглэл өөрчлөгдөж, ЗГ-ын 2023.11.22-ны өдрийн 411 дүгээр тогтоолоор Улаанбаатар хотын хөндлөн чиглэлд метро нэвтрүүлэхээр шийдвэрлэсэн бөгөөд тус төслийг "Улаанбаатар хотын авто замын | 2024.01.01-<br>2024.12.02 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж" УТҮГ-т<br>✓ "Шинэ тойрог зам" төслийг Нийслэлийн замын хөгжлийн газарт тус тус шилжүүлэхээр шийдвэрлэсэн.<br>Нийслэлийн удирдах ажилтнуудын 2024.04.01-ний өдрийн шуурхай зөвлөгөөнөөс тус компанийг татан буулгах ажлыг зохион байгуулах чиглэлийн дагуу НӨХГ-ын 2024.04.05-ны өдрийн 2/634 тоот албан бичгээр Компанийн тухай хуулийн дагуу татан буулгах ажлыг Хувьцаа эзэмшигчдийн болон Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, зохион байгуулахыг мэдэгдсэн.<br>Мөн тус компанийг татан буулгахтай холбоотой Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024.03.06, 2024.04.18, 2024.04.23-ны өдрийн хурлуудад орж, татан буулгах арга зүйн зөвлөгөө өгч, санал дүгнэлтээ өгөн ажилласан бөгөө ТУЗ-ийн хурлаас татан буулгах тогтоолын төслийг хэлэлцэн Хувьцаа эзэмшигчдийн хуралд 2024.04.23-ний өдрийн 31 тоот албан бичгээр хүргүүлсэн.<br>НИТХ-ын 2024.04.29-ний өдрийн хурлаар "Улаанбаатар шинэ бүтээн байгуулалт" ХХК-ийг татан буулгах асуудлыг хэлэлцэн, 61 дүгээр тогтоолоор 2024.04.30-ний өдрөөр | 2024.01.01-2024.12.02 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | татан буулгахаар шийдвэрлэсэн.<br>Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны 11 дүгээр сарын 31-ний өдрийн А/256 дугаар тушаалаар "Улаанбаатар шинэ бүтээн байгуулал" ХХК-ийн балансад бүртгэлтэй нийт 454,097,108.89 төгрөгийн эргэлтийн бус хөрөнгийг тус газрын балансад шилжүүлсэн.<br><br>➢ ***Улаанбаатар зүүн азийн наадам зохион байгуулах хороо ХК***<br><br>Тус компани нь "Улаанбаатар 2023" Зүүн Азийн залуучуудын наадмыг зохион байгуулах зорилгоор НийслэлийнИргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 214 дүгээр тогтоолоор байгуулагдсан бөгөөд тус наадмыг 2023.08.16-2023.08.23-ны өдрүүдэд зохион байгуулж дууссан.<br>Иймд НӨХГ-ын 2023.11.01-ний өдрийн 2/1320, 2024.04.04-ний өдрийн 2/609 тоот албан бичгээр Компанийн тухай хуулийн дагуу татан буулгах асуудлыг Хувьцаа эзэмшигчдийн болон Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх арга хэмжээ авч ажиллахыг мэдэгдсэн.<br>НЗД-ын 2024.05.10-ны өдрийн | 2024.01.01-<br>2024.12.02 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | А/511 дүгээр захирамжаар “Нийслэлийн өмчит Улаанбаатар зүүн азийн наадам зохион байгуулах хороо” ХК-д бүртгэлтэй спортын хэрэгсэл, техник, тоног төхөөрөмжид тооллого хийх, бүртгэл, элэгдэл хорогдлыг тооцох үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан.<br>Тус ажлын хүрээнд 2024.05.13-ний өдөр Баянзүрх дүүргийн Улиастайд байрлах цэргийн ангийн хашаан дахь агуулахад байсан хөрөнгийг Монголын хүүхдийн ордонд, 2024.05.14-ний өдөр Хүй-7 худаг дахь Монгол наадам цогцолбор ОНӨТҮГ-ын агуулах дахь хөрөнгүүдийг Монголын хүүхдийн ордон, Нийслэлийн Бизнес инновац хөгжлийн газарт тус тус хүлээлгэн өгөөд байна.<br>Нийслэлийн Засаг даргын 2024 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 01/5224 дүгээр албан бичгээр Нийслэлийн өмчит “Улаанбаатар зүүн азийн залуучуудын наадам зохион байгуулах хороо” ХК-ийг татан буулгах асуудлыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн барьж, хэлэлцүүлэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн 122 дугаар тогтоолоор тус газрын татан буулгахаар шийдвэрлэж, татан буулгахтай холбогдох ажиллагааг зохион | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байгуулахыг Нийслэлийн Засаг даргад даалгасан.<br>Нийслэлийн Засаг даргын 2024 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн А/1299 дүгээр захирамжаар тус компанийг татан буулгах үүрэг бүхий Комиссын бүрэлдэхүүнийг батлуулсан.<br><br>➤ ***Нийслэлийн нутгийн захиргааны цогцолбор барилгын ашиглалтын өмнөх захиргаа ОНӨТҮГ***<br>Тус газар нь нийслэлийн нутгийн захиргааны цогцолбор барилгыг ашиглалтад оруулах бэлтгэл ажлыг хангах зорилгоор НИТХ-ын 2019 оны 182 дугаар тогтоолоор байгуулсан бөгөөд дүрэмд тусгагсан үндсэн чиг үүрэг хэрэгжиж нийслэлийн нутгийн захиргааны цогцолбор барилга ашиглалтад орсон тул тус үйлдвэрийн газрыг татан буулгах асуудлыг Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2024 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн хурлаар, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн 2024 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн хурлаар тус тус хэлэлцүүлэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хуралд өргөн барихыг үүрэг болгов.<br><br>Нийслэлийн Засаг даргын | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 2024 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 01/5225 дугаар албан бичгээр "Нийслэлийн нутгийн захиргааны цогцолбор барилгын ашиглалтын өмнөх захиргаа" ОНӨТҮГ-ыг татан буулгах асуудлыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн барьж, хэлэлцүүлэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн 122 дугаар тогтоолоор татан буулгахаар шийдвэрлэж, татан буулгах ажиллагааг зохион байгуулахыг Нийслэлийн Засаг даргад үүрэг болгосон.<br>Нийслэйн Засаг даргын 2024 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн 122 дугаар захирамжаар тус үйлдвэрийн газрыг татан буулгах үүрэг бүхий Комиссын бүрэлдэхүүнийг батлуулсан. | | |
| ХОЁР. БАЙГУУЛЛАГЫН ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН ҮНДСЭН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД: | | | | | | | |
| *2.1. "Нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын захиралтай "Онцгой нөхцөлтэй хөдөлмөрийн гэрээ" байгуулах ажлыг зохион байгуулах, хэрэгжилтэд нь хяналт тавих" зорилтын хүрээнд:* | | | | | | | |
| 2 | **Арга хэмжээ № 2.1.1**<br>"Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар", "Ус сувгийн удирдах газар", "Хэсэгчилсэн инженерийн хангамжийн газар", "Улаанбаатар зам засвар, арчлалтын газар", "Багачууд хүнс", "Өсвөр үе | Байгууллагын тоо | 6 байгууллагын зорилтот түвшинг хянаж, батлуулан хүргүүлсэн байна. | Зорилтын биелэлтэд хяналт тавьж, биелэлтийг гаргуулсан байна. | Нийслэлийн Засаг даргын 2024 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн А/755 дугаар захирамжаар:<br>*"Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар" ОНӨААТҮГ*<br>Орлого-139,439,798.5 мян.төг<br>Зардал-159,103,302.3 мян.төг<br>Алдагдал-19,663,503.8 мян.төг<br>*"Ус сувгийн удирдах газар"* | 2024.01.01-2024.12.02 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хүнс" орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын 2024 оны эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтот түвшинг хянан танилцуулга бэлтгэх | | | | *ОНӨААТҮГ*<br>Орлого -130,455,649.9 мян.төг<br>Зардал- 133,792,633.8 мян.төг<br>Алдагдал-3,336,983.9 мян.төг<br>*"Хэсэгчилсэн инженерийн хангамжийн газар" ОНӨААТҮГ*<br>Орлого-14,578,769.0 мян.төг<br>Зардал-14,578,769.0 мян.төг<br>Ашиг,алдагдал-0<br>*"Улаанбаатар зам засвар, арчлалтын газар" ОНӨААТҮГ*<br>Орлого-13,031,318.0 мян.төг<br>Зардал-13,981,816.1 мян.төг<br>Ашиг-49,081.2 мян.төг<br>*"Багачууд хүнс" ОНӨААТҮГ*<br>Орлого-5,823,002.8 мян.төг<br>Зардал-5,750,800.8 мян.төг<br>Ашиг-72,202.0 мян.төг<br>*"Өсвөр үе хүнс" ОНӨААТҮГ*<br>Орлого-11,465,951.1 мян.төг<br>Зардал-11,457,463.9 мян.төг<br>Ашиг-8,487.2 мян төг байхаар 2024 оны эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтот түвшинг тус тус батлуулсан. | | |
| 3 | **Арга хэмжээ № 2.1.2.**<br>"Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар", "Ус сувгийн удирдах газар", "Хэсэгчилсэн инженерийн хангамжийн газар", "Улаанбаатар зам засвар, арчлалтын газар", "Багачууд хүнс", "Өсвөр үе хүнс" орон нутгийн өмчит | Байгууллагын тоо | 6 байгууллагын 2023 оны зорилтын биелэлтийг гарган дүн шинжилгээ хийсэн байна. | 2024 оны зорилтын биелэлтэд хяналт тавьж, эдийн засгийн дүн шинжилгээ хийсэн байна. | Нийслэлийн Засаг даргын 2024 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн А/755 дугаар захирамжаар 2023 оны эдийн засгийн зорилтот түвшний биелэлтээр:<br>*"Бүрэн хангалттай" үнэлэгдсэн дараах газрууд байна. Үүнд:*<br>Алдагдлыг бууруулж ажилласан:<br>*"Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар" ОНӨААТҮГ* | 2024.01.01-2024.12.02 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын 2023 оны эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтот түвшинг дүгнэх, | | | | Зорилт-(19,473,306.0 )мян.төг<br>Гүйцэтгэл-(8,060,202.6) мян.төг<br>*"Ус сувгийн удирдах газар" ОНӨААТҮГ*<br>Зорилт-(18,579,670.1) мян.төг<br>Гүйцэтгэл-(7,631,225.5) мян.төг<br>Ашгийн төлөвлөгөөг давуулсан:<br>*"Хэсэгчилсэн инженерийн хангамжийн газар" ОНӨААТҮГ*<br>Зорилт-0 төгрөг<br>Гүйцэтгэл-8,971.5 мян.төг<br>"Багачууд хүнс" ОНӨААТҮГ<br>Зорилт-76,906.8 мян.төг<br>Гүйцэтгэл-99,701.9 мян.төг<br>*"Хангалттай" үнэлэгдсэн дараах газрууд байна. Үүнд:*<br>- "Улаанбаатар зам засвар, арчлалтын газар" ОНӨААТҮГ<br>- "Өсвөр үе хүнс" ОНӨААТҮГ | | |
| 4 | **Арга хэмжээ № 2.1.3.**<br>Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын захиралтай Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах ажлыг зохион байгуулах | Байгууллагын тоо | 6 байгууллагын захиралтай "Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ"-ний төслийг боловсруулна. | "Онцгой нөхцөлтэй хөдөлмөрийн гэрээ" байгуулсан байна. | "Онцгой нөхцөлтэй хөдөлмөрийн гэрээ"-г 2024 оны дүгээр сарын ний өдөр дараах газруудтай байгуулан, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчаар батлуулав.<br>- Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар ОНӨААТҮГ<br>- Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ<br>- Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар ОНӨААТҮГ<br>- Улаанбаатар зам засвар, арчлалтын газар ОНӨААТҮГ | 2024.01.01-2024.12.02 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | - Багачууд хүнс ОНӨААТҮГ<br>- Өсвөр үе хүнс ОНӨААТҮГ | | |
| **2.2.** *Нийслэлийн өмчийн төлөөлөл, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих* | | | | | | | |
| 5 | **Арга хэмжээ № 2.2.4.**<br>УЗ, ТУЗ-ийн гишүүдэд нийслэлд холбогдох мэргэжлийн байгууллагаас төлөөлөл зайлшгүй оруулах | Тогтоолын тоо | Холбогдох газруудаас ирүүлсэн хүсэлтийг үндэслэн НИТХ-аар хэлэлцүүлнэ. | Холбогдох газруудаас ирүүлсэн хүсэлтийг үндэслэн НИТХ-аар хэлэлцүүлнэ. | ✓ НИТХ-ын 2024.02.08-ны өдрийн 22 дугаар тогтоолоор нийслэлийн өмчит болон нийслэлийн өмчийн оролцоотой 14 хуулийн этгээдийн ТУЗ болон УЗ-ийн 20 гишүүнийг чөлөөлөх,<br>✓ НИТХ-ын 2024.02.08-ны өдрийн 23 дугаар тогтоолоор 16 хуулийн этгээдийн 38 гишүүнийг томилуулах асуудлыг хэлэлцүүлсэн бөгөөд НӨХГ-ын 2024.02.29-ний өдрийн 2/336-2/350 тоот албан бичгээр тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг холбогдох газруудад хүргүүлсэн.<br>✓ НИТХ-ын 2024.04.18-ны өдрийн 46 дугаар тогтоолоор орон нутгийн өмчит 3 хуулийн этгээдийн 6 гишүүнийг чөлөөлж, 2 гишүүнийг томилуулсан бөгөөд НӨХГ-ын 2024.05.17-ны өдрийн 2/901-2/903 тоот албан бичгээр тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг тус газруудад хүргүүлсэн байна.<br>✓ НИТХ-ын 2024.06.13-ны өдрийн 83 дугаар тогтоолоор "Төв цэнгэлдэх хүрээлэн" ХХК-ийн ТУЗ-ийн 6 гишүүнийг томилуулав.(НЗД-ын 2024.06.05- | 2024.01.01-2024.12.02 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ны өдрийн 01/3305 тоот албан бичгээр "Төв цэнгэлдэх хүрээлэн" ХХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг чөлөөлж, томилох асуудлыг НИТХ-д хүргүүлж, хэлэлцүүлж байна.)<br>✓ НИТХ-ын 2024.06.13-ны өдрийн 84 дүгээр тогтоолоор "Зорчигч тээвэр тав" ОНӨААТҮГ-ын УЗ-ийн гишүүдийг томилуулав. (НЗД-ын 2024.06.04-ний өдрийн 01/3280 тоот албан бичгээр "Зорчигч тээвэр тав" ОНӨААТҮГ-ын удирдах зөвлөлийн гишүүдийг томилох асуудлыг НИТХ-д хүргүүлж, хэлэлцүүлсэн.)<br>✓ НИТХ-ын 2024.07.24-ний өдрийн 102 дугаар тогтоолоор 3 хуулийн этгээдийн ТУЗ-ийн 12 гишүүнийг томилуулсан. | | |
| 6 | **Арга хэмжээ: № 2.2.5**<br>Нийслэлийн өмчит болон нийслэлийн өмчийн оролцоотой хуулийн этгээдээс нийслэлийн төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийн тооцоог гаргаж, санал боловсруулан шийдвэрлүүлэх | -Ногдол ашиг мөнгөн дүн<br>-Хуулийн этгээдийн тоо | Нийслэлийн өмчит хуулийн этгээдүүдийн аудитлагдсан тайланг нэгтгэн, НИТХ-ын тогтоолын төслийг боловсруулан, хуралд хүргүүлж шийдвэрлүүлнэ | НИТХ-ын тогтоосон ногдол ашгийг нийслэлийн төсөвт төвлөрүүлэх ажлыг зохион байгуулна. | Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024.07.24-ний өдрийн 97 дугаар тогтоолоор Нийслэлийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газруудын 2023 оны санхүүгийн тайлангийн цэвэр ашгаас 30 хувиар тооцох 2024 оны нийслэлийн төсөвт нийт 1,340,522,200.00 (нэг тэрбум гурван зуун дөчин сая таван зуун хорин хоёр мянга хоёр зуу) төгрөгийн ногдол ашгийг төвлөрүүлэхээр шийдвэрлэсэн. Үүнд:<br>- Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ- | 2024.01.01-2024.12.02 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 608,040.39 мянган төгрөг;<br>- Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ – 312,834.7 мянган төгрөг;<br>- Гэрлэх ёслолын ордон ОНӨААТҮГ – 143,450.6 мянган төгрөг;<br>- Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ- 124,992.8 мянган төгрөг;<br>- Хүнс хангамж төв ОНӨААТҮГ – 67,712.7 мянган төгрөг;<br>- Асгат ОНӨААТҮГ – 53,470.5 мянган төгрөг;<br>- Багачууд хүнс ОНӨААТҮГ – 26,919.5 мянган төгрөг;<br>- Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар ОНӨААТҮГ – 679,0 мянган төгрөг. | | |
| ***2.3.*** *"Нийслэлийн өмчийн эзэмшилт, ашиглалтын байдалд хяналт тавьж, хариуцлагыг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх" зорилтын хүрээнд:* | | | | | | | |
| 7 | **Арга хэмжээ № 2.3.1.**<br>"Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ"-г шинэчлэн байгуулах | Байгууллагын тоо | 10 байгууллагад гэрээний төслийг хүргүүлсэн байна. | Гэрээг хянан баталгаажуулна. | БЗД-ийн дараах газруудын захиралтай "Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ"-г шинэчлэн байгуулаад байна.<br>1. Нийслэлийн Жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих төв ОНӨТҮГ<br>2. Бодлогын судалгаа, шинжилгээний төв ОНӨТҮГ<br>3. Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж ОНӨТҮГ | 2024.01.01-2024.12.02 | 100 |

150

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 4. Баянзүрх Дүүргийн хөгжлийн төв ОНӨААТҮГ<br>5. "Хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын төв" ОНӨААТҮГ<br>6. "Иргэд, олон нийтэд үйлчлэх төв" ОНӨААТҮГ<br>7. "Баянзүрх эко тохижилт, үйлчилгээ" ОНӨААТҮГ<br>8. "Олон улсын эко цэцэрлэгт хүрээлэн" ОНӨААТҮГ<br>9. "Усан спорт сургалтын төв" ОНӨААТҮГ<br>10. БДЗ-ийн Жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих төв УТҮГ | | |
| 8 | **Арга хэмжээ № 2.3.2.**<br>"Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ"-ний 2023 оны биелэлтийг дүгнэх ажлыг зохион байгуулах, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээ авах | Байгууллагын тоо, дүн | Гэрээ дүгнэх ажлыг зохион байгуулсан байна. Гэрээний биелэлтийг дүгнэж, дүүргийн дүнг танилцуулгын хамт бэлтгэнэ. | Илэрсэн зөрчлийн арилгуулах арга хэмжээ авна. | НӨХГ-ын 2024.05.29-ны өдрийн А/90 дугээр тушаалаар "Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ"-ний 2023 оны биелэлтийг дүгнэх ажлыг зохион байгуулах, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээ авах үүрэг бүхий ажлын хэсэгт орж Хан-Уул, Баянзүрх дүүргийн өмчит үйлдвэрийн газруудад ажиллаж холбогдох санал, зөвлөмжийг өгч ажиллан, ажлын тайлангаа нэгтгүүлсэн. | 2024.01.01-2024.12.02 | 100 |
| **2.4.** "*Нийслэлийн өмчийн эд хөрөнгийн хөдөлгөөн түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах, хөрөнгийн хөдөлгөөнд хяналт тавих зорилт " зорилтын хүрээнд:* | | | | | | | |
| 9 | **Арга хэмжээ № 2.4.2.**<br>Төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд баригдаж ашиглалтад орсон барилга байгууламж, бий болсон тээврийн хэрэгсэл, тохижилтын | Бүртгэсэн хөрөнгийн дүн, сая.төг | Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон эргэлтийн бус хөрөнгийг эзэмшигч | Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон эргэлтийн бус хөрөнгийг эзэмшигч | ***НИТХ-ын тогтоолоор бүртгэсэн:***<br>**Нийт- 41,111,230,708.67 төгрөг**<br>✓ НИТХ-ын 2024.03.25-ны өдрийн 33 дугаар тогтоол, НЗД-ын 2024.04.19-ний өдрийн А/438 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ажлуудыг нийслэлийн өмчид буюу нийслэлийн өмчит төсөвт байгууллагын бүртгэлд тусгах ажлыг зохион байгуулах, | | байгууллагын дансанд тусгуулна. | байгууллагын дансанд тусгуулна. | дугаар захирамжаар Азийн хөгжлийн банкны зээлийн санхүүжилт болон нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж, ашиглалтад орсон нийт 24,597,481,091.36 (хорин дөрвөн тэрбум таван зуун ерэн долоон сая дөрвөн зуун наян нэгэн мянга ерэн нэгэн төгрөг гучин зургаан мөнгө) төгрөгийн өртөг бүхий Сэлбэ дэд төвийн дулааны станцын барилга байгууламжийг Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газарт бүртгэхээр шийдвэрлэж, НӨХГ-ын 2024.04.22-ны өдрийн 2/737 тоот албан бичгээр тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг мэдэгдэв.<br>✓ НИТХ-ын 2024.09.19-ний өдрийн 114 дүгээр тогтоол, НЗД-ын 2024.11.04-ний өдрийн А/1293 дугаар захирамж 4,189,631,201.93 (дөрвөн тэрбум нэг зуун наян есөн сая зургаан зуун гучин нэгэн мянга хоёр зуун нэг төгрөг ерэн гурван мөнгө) төгрөгийн өртөг бүхий Сэлбэ дэд төвийн 2 дугаар хэлхээ болон 960 хүүхдийн сургуулийн 1-р хэлхээ УДДТ12-С 2-р хэлхээний дулаан хангамж, хэрэглээний ус, цэвэр усны шугам сүлжээний ажлыг Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар ОНӨААТҮГ-т, нийт | 2024.01.01-2024.06.31 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 12,324,118,415.38 (арван хоёр тэрбум гурван зуун хорин дөрвөн сая нэг зуун арван найман мянга дөрвөн зуун арван таван төгрөг гучин найман мөнгө) төгрөгийн өртөг бүхий Морингийн даваа орчмын шинэ суурьшлын бүсийн усан насос, станцын барилга, шугам сүлжээний ажлыг Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-т бүртгэхээр шийдвэрлэж, НӨХГ-ын 2024.11.07-ны өдрийн 3/1875-р албан бичгээр тогтоолын хэрэгжилтийг хангах ажиллахыг тус тус мэдэгдэв.<br><br>***Албан бичгээр бүртгэсэн:***<br><br>***Нийт – 8,243,104,572.4 (найман тэрбум хоёр зуун дөчин гурван сая нэг зуун дөрвөн мянга таван зуун далан хоёр төгрөг)***<br><br>✓ НӨХГ-ын 2024.02.20-ны өдрийн 2/276 тоот албан бичгээр "Агаарын бохирдлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлт"-ийн хөрөнгөөс Баянзүрх дүүргийн 8, 16, 19 дүгээр хороо, Газарчин, Эрдэнэ-Толгой орчмын хэрэглэгчдийг төвлөрсөн дулаан хангамжид холбох ажил хийгдсэн тул 1,529,817,615 /нэг тэрбум таван зуун хорин есөн сая найман | 2024.01.01-2024.12.02 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | зуун арван долоон мянга зургаан зуун арван тав/ төгрөгийн өртөг бүхий хөрөнгийг бүртгэн авахыг "Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар" ОНӨААТҮГ-т мэдэгдэв.<br>✓ НӨХГ-ын 2024.02.21-ний өдрийн 2/282 тоот албан бичгээр Сүхбаатар дүүргийн 9 дүгээр хорооны нутаг дэвсгэрт УДД-154 дүгээр төвийн 2-р хэлхээний халаалтын ф150 мм-ийн шугамыг ф250 мм болгон өргөтгөх ажил хийгдсэн тул 128,642,437 /нэг зуун хорин найман сая зургаан зуун дөчин хоёр мянга дөрвөн зуун гучин долоо/ төгрөгийн өртөг бүхий хөрөнгийг бүртгэн авахыг "Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар" ОНӨААТҮГ-т мэдэгдэв.<br>✓ НӨХГ-ын 2024.02.21-ний өдрийн 2/281 тоот албан бичгээр Сүхбаатар дүүргийн 248 дугаар цэцэрлэгийг гадна дулаан хангамж, ариутгах татуургад холбох ажил хийгдсэн тул 703,641,169 /долоон зуун гурван сая зургаан зуун дөчин нэгэн мянга нэг зуун жаран ес/ төгрөгийн өртөг бүхий хөрөнгийг бүртгэн авахыг тус цэцэрлэгт мэдэгдэв. | 2024.01.01-2024.12.02 | 100 |
| | | | | | ✓ НӨХГ-ын 2024.03.12-ны өдрийн 2/431 тоот албан бичгээр | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | төвлөрсөн дулаан хангамжийн нэгдсэн системд холбогдох боломжгүй алслагдсан халаалтын зуухыг шинэчлэх, байгальд ээлтэй технологи, нэмэлт тоноглол суурилуулах ажил хийгдсэн тул 340,551,523 /гурван зуун дөчин сая таван зуун тавин нэгэн мянга таван зуун хорин гурав/ төгрөгийн өртөг бүхий хөрөнгийг бүртгэн авахыг Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар ОНӨААТҮГ-т мэдэгдэв.<br>✓ НӨХГ-ын 2024.03.12-ны өдрийн 2/434 тоот албан бичгээр төвлөрсөн дулаан хангамжийн нэгдсэн системд холбогдох боломжгүй алслагдсан халаалтын зуухыг шинэчлэх, байгальд ээлтэй технологи, нэмэлт тоноглол суурилуулах ажил хийгдсэн тул 27,460,218 /хорин долоон сая дөрөн зуун жаран мянга хоёр зуун арван найм/ төгрөгийн өртөг бүхий хөрөнгийг бүртгэн авахыг Сүхбаатар дүүргийн Жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих төвд мэдэгдэв.<br>✓ НӨХГ-ын 2024.03.25-ны өдрийн 2/504 тоот албан бичгээр Баянзүрх дүүргийн 4 дүгээр хороо Ус, дулаан дамжуулах 10-р төвийн 1 дүгээр хэлхээний гадна дулааны шугам сүлжээг шинээр холбох ажил хийгдсэн тул 681,664,577.00 | 2024.01.01-2024.12.02 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | /зургаан зуун наян нэгэн сая зургаан зуун жаран дөрвөн мянга таван зуун тавин долоо/ төгрөгийн хөрөнгийг бүртгэн авахыг "Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар" ОНӨААТҮГ-т мэдэгдэв.<br>✓ НӨХГ-ын 2024.04.09-ний өдрийн 2/661 тоот албан бичгээр "Баянзүрх эко тохижилт, үйлчилгээ" ОНӨААТҮГ-ын Автобаазын агааржуулалтын засварын ажлыг хийсэн тул 149,522,923 /нэг зуун дөчин есөн сая таван зуун хорин хоёр мянга есөн зуун хорин гурав/ төгрөгийн өртөг бүхий хөрөнгийг бүртгэн авахыг тус газарт мэдэгдэв.<br>✓ НӨХГ-ын 2024.04.09-ний өдрийн 2/662 тоот албан бичгээр Олон улсын эко цэцэрлэгт хүрээлэнгийн гадна хашаа, тохижилтын ажлыг хийсэн тул 920,471,460 /есөн зуун хорин сая дөрвөн зуун далан нэгэн мянга дөрвөн зуун жар/ төгрөгийн өртөг бүхий хөрөнгийг бүртгэн авахыг тус газарт мэдэгдэв.<br>✓ НӨХГ-ын 2024.05.17-ны өдрийн 2/891 тоот албан бичгээр Шар хад дэд төвийн хүрээнд Баянзүрх дүүргийн 19 дүгээр хороонд баригдаж буй "Цайз эко хотхон" ногоон орон сууцны төслийн гадна инженерийн шугам сүлжээний барилга угсралтын ажлын хүрээнд | 2024.01.01-<br>2024.12.02 | 100 |

153

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | бий болсон 2ф300/250 мм голчтой 578 хос метр урттай шугамыг хүлээн авсан актыг үндэслэн нийт 1,651,178,493.04 /нэг тэрбум зургаан зуун тавин нэгэн сая нэг зуун далан найман мянга дөрвөн зуун ерэн гурав/ төгрөгийн өртөг бүхий хөрөнгийг бүртгэн авахыг авахыг "Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар" ОНӨААТҮГ-т мэдэгдэв.<br>✓ НӨХГ-ын 2024.05.29-ний өдрийн 2/976 тоот албан бичгээр Баянгол дүүргийн 2 дугаар хороо, 26, 27 дугаар байруудыг буулгаж, дахин барилгажуулах төслийн хүрээнд шинээр баригдах 16 давхар барилгын гадна инженерийн шугам сүлжээний ажлыг хийсэн тул 2,123,964,822 /хоёр тэрбум нэг зуун хорин гурван сая есөн зуун жаран дөрвөн мянга найман зуун хорин хоёр/ төгрөгийн өртөг бүхий хөрөнгийг бүртгэн авахыг "Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар" ОНӨААТҮГ-т мэдэгдэв. | | |
| 10 | **Арга хэмжээ № 2.4.3.**<br>Хандив бэлэглэл, буцалтгүй тусламж, зээл, төсөл хөтөлбөрөөр бий болсон эд хөрөнгийг холбогдох журмын дагуу нийслэлийн өмчид бүртгэх ажлыг зохион байгуулах | Бүртгэсэн хөрөнгийн дүн, сая.төг | Хандив, тусламжаар бий болсон эргэлтийн бус хөрөнгийг эзэмшигч байгууллагын дансанд | Хандив, тусламжаар бий болсон эргэлтийн бус хөрөнгийг эзэмшигч байгууллагын дансанд | ***НИТХ-ын тогтоолоор:***<br>***нийт-157,140,000.00төгрөг***<br>Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024.06.13-ны өдрийн 77 дугаар тогтоол, НЗД-ын 2024.07.31-ний өдрийн А/917 дугаар захирамжаар Монгол Улсын Дээд шүүхийн 2023 оны 15 дугаар | 2024.01.01-2024.12.02 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | тусгуулна. | тусгуулна. | тогтоолыг үндэслэн 157,140,000.00 (нэг зуун тавин долоон сая нэг зуун дөчин мянга) төгрөгийн хөрөнгийг Өсвөр үе хүнс ОНӨААТҮГ-ын балансад бүртгэхээр шийдвэрлэж, НӨХГ-ын 2024.08.01-ний өдрийн 2/1400 тоот албан бичгээр тогтоол, захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг мэдэгдэв. | | |
| 11 | **Арга хэмжээ № 2.4.4.** Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн балансад бүртгэлтэй ашиглалтын шаардлага хангахгүй барилга байгууламжийг акталж, данснаас хасах | Акталсан барилгын тоо Мөнгөн дүн сая.төг | Нийслэлийн өмчит хуулийн этгээдээс ирүүлсэн хүсэлтийн дагуу асуудлыг судлан холбогдох хууль тогтоомж, журмын дагуу шийдвэрлүүлнэ. | Нийслэлийн өмчит хуулийн этгээдээс ирүүлсэн хүсэлтийн дагуу асуудлыг судлан холбогдох хууль тогтоомж, журмын дагуу шийдвэрлүүлнэ. | ***НИТХ-ын тогтоолоор: нийт – 92,584,222.98 төгрөг*** <br>✓ НИТХ-ын 2024.04.29-ний өдрийн 51 дүгээр тогтоолоор "Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар" ОНӨААТҮГ-ын балансад бүртгэлтэй 91,049,809.98 (ерэн нэгэн сая дөчин есөн мянга найман зуун есөн төгрөг ерэн найман мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэтэй, 65,166,149.77 (жаран таван сая нэг зуун жаран зургаан мянга нэг зуун дөчийн есөн төгрөг далан долоон мөнгө) төгрөгийн үлдэх өртөг бүхий хавсралтад заасан 3 барилга байгууламжийг акталж, нийслэлийн өмчийн бүртгэлээс хасахаар шийдвэрлэж, НӨХГ-ын даргын 2024.06.26-ны өдрийн А/158 дугаар тушаалаар данс бүртгэлээс хасч, холбогдох арга хэмжээг авахыг тус газарт үүрэг болгов. <br>✓ НИТХ-ын 2024.07.24-ний өдрийн 96 дугаар тогтоол, НЗД-ын | 2024.01.01-2024.12.02 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 2024.08.29-ний өдрийн А/1038 дугаар захирамжаар "Орон сууц нийтийн удирдах газар" ОНӨААТҮГ-ын балансад бүртгэлтэй 1,534,413 (нэг сая таван зуун гучин дөрвөн мянга дөрвөн зуун арван гурав) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий бохир соруулах барилга, тоног төхөөрөмжийг нийслэлийн өмчийн бүртгэлээс хасахаар шийдвэрлэж, НӨХГ-ын 2024.09.09-ний өдрийн 2/1552 тоот албан бичгээр тогтоол, захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг мэдэгдэв. | | |
| 12 | **Арга хэмжээ:№ 2.4.5** Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн балансад бүртгэлтэй ашиглалтын шаардлага хангахгүй тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, биет бус хөрөнгийг акталж, данснаас хасах | Акталсан хөрөнгийн дүн, сая.төг | Нийслэлийн өмчит хуулийн этгээдээс ирүүлсэн хүсэлтийн дагуу асуудлыг судлан холбогдох хууль тогтоомж, журмын дагуу шийдвэрлүүлнэ | Нийслэлийн өмчит хуулийн этгээдээс ирүүлсэн хүсэлтийн дагуу асуудлыг судлан холбогдох хууль тогтоомж, журмын дагуу шийдвэрлүүлнэ | ***ҮХХХК-ийн хурлаар:*** Нийт- 1,614,127,799.95 төгрөгийн ашиглалтын шаардлага хангахгүй тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, биет бус хөрөнгийг данс бүртгэлээс хасах шийдвэрийг гаргуулав. Үүнд:<br>✓ Тоног төхөөрөмж-124,863,786.9<br>✓ Тавилга эд хогшил-75,760,694.5<br>✓ Бусад-1,337,448,532.3<br>✓ Биет бус-4,636,486.17<br>✓ Нийтийн эзэмшлийн хөрөнгө-71,418,300.0 | 2024.01.01-2024.12.02 | 100 |
| 13 | **Арга хэмжээ: № 2.4.6** Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн хүсэлтийн дагуу барилга байгууламж, тээврийн хэрэгсэл, бусад хөрөнгийг балансаас | Балансаас балансад шилжүүлсэн хөрөнгийн | Нийслэлийн өмчит хуулийн этгээдээс ирүүлсэн хүсэлтийн дагуу асуудлыг | Нийслэлийн өмчит хуулийн этгээдээс ирүүлсэн хүсэлтийн дагуу асуудлыг | ***НЗД-ын захирамжаар:*** ***Нийт-1,422,975,000.0 төгрөг***<br>✓ НЗД-ын 2024.04.04-ний А/378 дугаар захирамжаар "Нийтлэг үйлчилгээний газар -2,3,4" ОНӨААТҮГ-уудын балансад | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | балансад шилжүүлэх | дүн сая.төг | судлан холбогдох хууль тогтоомж, журмын дагуу шийдвэрлүүлнэ. | судлан холбогдох хууль тогтоомж, журмын дагуу шийдвэрлүүлнэ. | бүртгэлтэй 1,198,400,000 төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий 7 тээврийн хэрэгслийг "Баянзүрх Эко тохижилт, үйлчилгээ" ОНӨААТҮГ-ын балансад шилжүүлэхээр шийдвэрлэж, НӨХГ-ын 2024.04.08-ны өдрийн 2/639 тоот албан бичгээр захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг мэдэгдэв.<br>✓ НЗД-ын 2023.06.10-ны өдрийн А/682 дугаар захирамжаар Баянзүрх эко тохижилт, үйлчилгээ ОНӨААТҮГ-ын балансад бүртгэлтэй 224,575,000.0 төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий 2 тээврийн хэрэгслийг "Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын төв" ОНӨААТҮГ-ын балансад шилжүүлэхээр шийдвэрлэж, НӨХГ-ын 2024.06.13-ны өдрийн 2/1085 тоот албан бичгээр захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг мэдэгдэв.<br>***ҮХХХК-ийн шийдвэрээр:***<br>***нийт-869,293,591.39 төгрөг***<br>✓ НӨХГ-ын даргын 2024.....-ний өдрийн А/ дугаар тушаалаар Баянзүрх дүүргийн Нийтлэг үйлчилгээний газар -1, 2, 3, 4 ОНӨААТҮГ-уудын балансад бүртгэлтэй нийт **371,696,482.50** (гурван зуун далан нэгэн сая | 2024.01.01-2024.12.02 | 100 |

155

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | зургаан зуун ерэн зургаан мянга дөрвөн зуун наян хоёр төгрөг тавин мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Баянзүрх эко тохижилт, үйлчилгээ ОНӨААТҮГ-ын балансад шилжүүлэхээр шийдвэрлэв.<br>✓ НӨХГ-ын даргын 2024.11.31-ний өдрийн А/256 дугаар тушаалаар "Улаанбаатар шинэ бүтээн байгуулал" ХХК-ийн балансад бүртгэлтэй нийт 454,097,108.89 (дөврөн зуун тавин дөрвөн сая ерэн долоон мянга нэг зуун найман төгрөг наян есөн мөнгө) төгрөгийн эргэлтийн бус хөрөнгийг тус газрын балансад шилжүүлэв.<br>✓ НӨХГ-ын даргын 2024.10.17-ны өдрийн А/387 дугаар тушаалаар нийт Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар ОНӨААТҮГ-ын балансадб бүртгэлтэй 43,500,000.0 (дөчин гурван сая таван зуун мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий тоног төхөөрөмжийг Багахангай дүүргийн Илч орд ОНӨААТҮГ-ын балансад шилжүүлэв. | | |
| 14 | **Арга хэмжээ: № 2.4.7**<br>Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн хүсэлтийн дагуу эд хөрөнгийг данснаас дансанд шилжүүлж, залруулга хийх асуудлыг шийдвэрлэх | Данснаас дансанд шилжүүлсэн хөрөнгийн дүн, сая төг | Нийслэлийн өмчит хуулийн этгээдээс ирүүлсэн хүсэлтийн дагуу асуудлыг судлан | Нийслэлийн өмчит хуулийн этгээдээс ирүүлсэн хүсэлтийн дагуу асуудлыг судлан | ***ҮХХХК-ийн шийдвэрээр:***<br>Нийт-152,040,543.69 төгрөгийн хөрөнгийг данс хооронд залруулан бүртгэхээр шийдвэрлэв. Үүнд:<br>Тоног төхөөрөмжөөс бараа материалын дансад-932,400.0 төгрөг<br>Бусад үндсэн хөрөнгийн данснаас | 2024.01.01- | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | холбогдох хууль тогтоомж, журмын дагуу шийдвэрлүүлнэ | холбогдох хууль тогтоомж, журмын дагуу шийдвэрлүүлнэ | тоног төхөөрөмжийн дансанд-151,107,843.69 | 2024.12.02 | |
| 15 | **Арга хэмжээ № 2.4.8** Нийслэлийн өмчит байгууллагуудад шаардлагатай хөрөнгө худалдан авах зөвшөөрөл олгох | Хөрөнгийн тоо, мөнгөн дүн | Нийслэлийн өмчит хуулийн этгээдээс ирүүлсэн хүсэлтийн дагуу асуудлыг судлан холбогдох хууль тогтоомж, журмын дагуу шийдвэрлүүлнэ. | Нийслэлийн өмчит хуулийн этгээдээс ирүүлсэн хүсэлтийн дагуу асуудлыг судлан холбогдох хууль тогтоомж, журмын дагуу шийдвэрлүүлнэ. | "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль", Засгийн газрын 2024 оны "Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай" 02 дугаар тогтоолыг баримтлан худалдан авах ажиллагаг зохион байгуулж ажиллахыг дараах газруудад мэдэгдсэн.<br>1. НӨХГ-ын 2024.02.16-ны өдрийн 2/258 тоот албан бичгээр Орон сууц нийтийн удирдах газарт,<br>2. НӨХГ-ын 2024.04.08-ны өдрийн 2/640 тоот албан бичгээр Ус сувгийн удирдах газарт,<br>3. НӨХГ-ын 2024.04.23-ны өдрийн 2/740 тоот албан бичгээр Баянзүрх эко тохижилт, үйлчилгээ ОНӨААТҮГ-т. | 2024.01.01-2024.12.02 | 100 |
| 16 | **Арга хэмжээ № 2.4.9.** Нийслэлийн өмчид үнэ төлбөргүй шилжин ирсэн нийтийн эзэмшлийн эд хөрөнгийг бүртгэх | Хөрөнгийн тоо, мөнгөн дүн | Иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн асуудлыг судлан, боловсруулж, холбогдох хууль | Иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн асуудлыг судлан, боловсруулж, холбогдох хууль | ***НИТХ-ын тогтоолоор:***<br>***Нийт-2,481,114,144.67 төгрөг***<br><br>НИТХ-ын 2024.02.28-ны өдрийн 27 дугаар тогтоол, НЗД-ын 2024.04.09-ний өдрийн А/408 дугаар захирамжаар иргэн , аж ахуйн нэгж байгууллагаас нийслэлийн өмчид үнэ төлбөргүй шилжүүлсэн | 2024.01.01- | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | тогтоомж, журмын дагуу шийдвэрлүүлнэ. | тогтоомж, журмын дагуу шийдвэрлүүлнэ. | 2,481,114,144.67 (хоёр тэрбум дөрвөн зуун наян нэгэн сая нэг зуун арван дөрвөн мянга нэг зуун дөчин дөрвөн төгрөг жаран долоон мөнгө) төгрөгийн орон сууцны барилгын инженерийн шугам сүлжээ, узелийн тоног төхөөрөмжийг "Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар" ОНӨААТҮГ-т бүртгэхээр шийдвэрлэж, НӨХГ-ын 2024.04.09-ний өдрийн 2/660 тоот албан бичгээр тогтоол, захирамжийн биелэлтийг хангаж ажиллахыг мэдэгдэв. | 2024.12.02 | |
| 17 | **Арга хэмжээ № 2.4.10** Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хүлээн авч, мэдээллийн санг бүрдүүлэх *(Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль)* | Байгууллагын тоо | Хариуцсан байгууллагуудын 2023 оны жилийн эцсийн тайланг хянан, илгээнэ. | Хяналт тавьж ажиллана. | Нийслэлийн өмчит дараах байгууллагуудын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг нягтлан , ТӨБЗГ-ын мэдээллийн санд нэгтгүүлсэн. Үүнд:<br>1. Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар ОНӨААТҮГ<br>2. Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар ОНӨААТҮГ<br>3. Улаанбаатар зам засвар арчлалтын газар ОНӨААТҮГ<br>4. Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар ОНААТҮГ<br>5. Багачуудхүнс ОНӨААТҮГ<br>6. Өсвөр үе хүнс ОНӨААТҮГ<br>7. Улаанбаатар спорт менежмент ХК<br>8. Улаанбаатар шинэ бүтээн байгуулалт ХХК<br>9. Улаанбаатар смарт карт ХХК | 2024.01.01-2024.12.02 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 10. Төв цэнгэлдэх хүрээлэн ХХК<br>11. Зүүн азийн наадам зохион байгуулах хороо ХК<br>12. Эмээлт аж үйлдвэрийн парк ХК<br>13. Улаанбаатар шинэ бүтээн байгуулалт ХХК<br>14. Бодлогын судалгаа, шинжилгээний төв ОНӨТҮГ<br>15. Нийслэлийн Жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих төв НӨҮГ<br>16. Улаанбаатар лифт ОНӨТҮГ<br>17. Нийслэлийн нутгийн захиргааны ашиглалтын өмнөх захиргаа ОНӨТҮГ<br>18. Баянзүрх Дүүргийн хөгжлийн төв ОНӨААТҮГ<br>19. "Хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын төв" ОНӨААТҮГ<br>20. "Иргэд, олон нийтэд үйлчлэх төв" ОНӨААТҮГ<br>21. "Баянзүрх эко тохижилт, үйлчилгээ" ОНӨААТҮГ<br>22. "Олон улсын эко цэцэрлэгт хүрээлэн" ОНӨААТҮГ<br>23. "Усан спорт сургалтын төв" ОНӨААТҮГ<br>24. БДЗ-ийн Жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих төв УТҮГ<br>25. Нийтлэг үйлчилгээний газар нэг ОНӨААТҮГ | 2024.01.01-<br>2024.12.02 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 26. Нийтлэг үйлчилгээний газар хоёр ОНӨААТҮГ<br>27. Нийтлэг үйлчилгээний газар гурав ОНӨААТҮГ<br>28. Нийтлэг үйлчилгээний газар дөрөв | | |
| 18 | **Арга хэмжээ: 2.4.11**<br>Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцах комиссын хурлыг зохион байгуулах, гарсан шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих | Хөрөнгийн дүн, сая төгрөг | Нийслэлийн өмчит болон нийслэлийн өмчийн оролцоотой байгууллагын хөрөнгийн хөдөлгөөний судалгааг 2023 оны хагас бүтэн жилээр гаргаж, ӨБМХ-ийн өмчийн нэгдсэн мэдээллийн санд нэгтгүүлэх | Нийслэлийн өмчит болон нийслэлийн өмчийн оролцоотой байгууллагын хөрөнгийн хөдөлгөөний судалгааг 2023 оны хагас бүтэн жилээр гаргаж, ӨБМХ-ийн өмчийн нэгдсэн мэдээллийн санд нэгтгүүлэх | Шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. | 2024.01.01-2024.12.02 | 100 |
| ГУРАВ. ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД | | | | | | | |
| ***3.1.*** *"Өмчийн харилцаатай холбоотой УИХ, Засгийн газар, Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал, Нийслэлийн Засаг дарга, нийслэлийн төр захиргааны байгууллагуудаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх, өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх" зорилтын хүрээнд* | | | | | | | |
| Зорилго 3. Байгууллагын захиргаа, хүний нөөц, төсөв санхүүтэй холбоотой арга хэмжээний хэрэгжилтийг хангаж ажиллах (Хуулиар олгогдсон нийтлэг чиг | | | | | | | |
| 19 | **Арга хэмжээ: № 3.1.3**<br>"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд хавар, намрын улиралд мод тарих | Тарьсан модны тоо Албан хаагчдын оролцоог хангуулах | Мод тарих арга хэмжээ 1-2 удаа оролцоно. | Мод тарих арга хэмжээ 1-2 удаа оролцоно. | "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд хавар, намрын улиралд мод тарих ажилд оролцсон. | 2024.01.01-2024.12.02 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 20 | **Арга хэмжээ: № 3.1.4** Албан хаагчийн албан үүргээ мэдлэг ур чадварыг дээшлүүлэх зорилтын хүрээнд зохион байгуулсан сургалт, семинар, олон нийтийн ажилд оролцох | Арга хэмжээний тоо | Сургалт, семинар, олон нийтийн ажилд оролцоно. | Сургалт, семинар, олон нийтийн ажилд оролцоно. | НЗДТГ болон байгууллагаас зохион байгуулж байгаа сургалт, семинарт хуваарийн дагуу оролцож байна. | 2024.01.01-2024.12.02 | 100 |
| ДӨРӨВ. "ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | | | |
| 21 | **Арга хэмжээ: № 4.1.1** Нийслэлийн Өмчийн ашиглалт удирдлагын газрын даргын 2019 оны А/169 дугээр тушаалаар батлагдсан албан хэрэг хөтлөлтийн журмыг үйл ажиллагаандаа дагаж мөрдөх | Албан бичгийн тоо, Зөрчлийн тоо | Албан бичгийн шийдвэрлэлтийн хувийг 95%-иас бууруулахгүй. | Албан бичгийн шийдвэрлэлтийн хувийг 95%-иас бууруулахгүй. | Тайлант хугацаанд нийт 225 албан бичиг ирүүлснээс 220 албан бичигт холбогдох хариуг хүргүүлж, 5 албан бичгийг судалж байна. | 2024.01.01-2024.12.02 | |
| 22 | **Арга хэмжээ: № 4.1.2** Өргөдөл гомдлыг хугацаанд нь шийдвэрлэх | Шийдвэрлэлтийн дундаж хугацааг 1 оронтой тоонд байлгах | Судлан, оновчтой шийдвэрлэн хариуг цаг алдалгүй утсаар болон, албан бичгээр мэдэгдэж байх, мэдээ тайланг хугацаанд нь холбогдох газруудад хүргүүлнэ. | Судлан, оновчтой шийдвэрлэн хариуг цаг алдалгүй утсаар болон, албан бичгээр мэдэгдэж байх, мэдээ тайланг хугацаанд нь холбогдох газруудад хүргүүлнэ. | Тайлант хугацаанд нийт 4 өргөдөл ирсэн байна. Хуулийн хугацаанд холбогдох хариуг хүргүүлж ажилласан. | 2024.01.01-2024.12.02 | 100 |
| 23 | **Арга хэмжээ: № 4.1.3** Байгууллагын албан | Хадгаламжийн | Архивын нэгжийг | | Тайлант хугацаанд үндсэн чиг үүргийн хүрээнд бий болсон нийт 10 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хаагчдын үйл ажиллагааны явцад үүссэн баримт материалыг хадгаламжийн нэгж үүсгэн архивт хүлээн авах | нэгжийн тоо | бүрдүүлэн хугацаанд нь графикийн дагуу өгөх | | боть материалыг архивын нэгж болгон хүлээлгэн өгсөн. | 2024.01.01-2024.12.02 | 100 |
| 24 | **Арга хэмжээ: № 4.1.4** Бодлогын баримт бичигт тусгагдсан ажлын хэрэгжилт, УИХ, ЗГ, НИТХ, НИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоол, НЗД-ын захирамж, шийдвэрийн биелэлтийг гарган тайлагнах | Тогтоол, шийдвэрийн тоо, биелэлтийн хувь /95-100%/ | Байгууллагын нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, тогтоол, захирамжийн хэрэгжилтийг гаргана. Тайлан мэдээг холбогдох хэлтэст хугацаанд нь хүргүүлнэ. | Байгууллагын нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, тогтоол, захирамжийн хэрэгжилтийг гаргана. Тайлан мэдээг холбогдох хэлтэст хугацаанд нь хүргүүлнэ. | Тайлант хугацаанд гаргасан хөрөнгийн хөдөлгөөнтэй холбоотой тогтоол, захирамжийн биелэлт мөн НЗД-ын шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын биелэлт, дээд байгууллагаас ирүүлсэн үүрэг даалгаврын биелэлтийг цаг тухай бүр гарган өгч ажилласан. | 2024.01.01-2024.12.02 | 100 |

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

| Д/Д | Боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвараа сайжруулах арга хэмжээ | Хүрэх түвшин | Хэрэгжүүлэх ажил | Хүрсэн түвшин биелэлт | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлт хувь |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | | 5 | |
| “ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ, САЛБАРЫН ХУУЛЬ, ДАГАЛДАН ГАРСАН ХУУЛЬ ТОГТООМЖИД ЗААСАН МЭДЛЭГ ЧАДВАРЫГ ЭЗЭМШИХ, ТАСРАЛТГҮЙ ХӨГЖҮҮЛЭХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | | |
| 1 | Төрийн албаны эрх зүйн баримт бичгүүдийг байнга гүнзгийрүүлэн судалж, ажилдаа тусган хэрэгжүүлж ажиллах | Төрийн албаны эрх зүйн баримт бичгүүдийг судлан, төрийн албаны ёс | Төрийн албаны эрх зүйн баримт бичгүүдийг байнга гүнзгийрүүлэн судлах, хариуцсан ажил үүргээ гүйцэтгэхэд зохистой мэдлэг, ур чадварыг байнга хөгжүүлнэ. | Үйл ажиллагаанд хэрэглэгдэж буй хууль, тогтоомж, дүрэм журмыг цаг тухай бүр судлан, хэрэгжүүлэн ажиллаж байна. МУИС-ийн Хуульзүйн сургуулийн оройн ангид элсэн орж, суралцаж байна. | 2024.01.01 - 2024.12.02 | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | зүйг мөрдөж ажиллана. | | | | |
| 2 | Хариуцсан ажил үүргээ гүйцэтгэхэд зохистой мэдлэг, ур чадвар, орчин үеийн мэдээллийн технологийн ололтыг чадамгай эзэмшиж, цаг үеийн эрэлт шаардлагад нийцүүлэн байнга хөгжүүлж, мэргэжлийн мэдлэг, ажил хэргийн нэгдлийг нягт хангаж ажиллах. | Ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай мэдлэг, мэдээлэл дээшилж, ажлын ур чадвар дээшилнэ. | - Оффис хэрэглээний болон ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай бусад программыг гүнзгийрүүлэн судлах.<br>- Ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай хууль, тогтоомж, журмыг ажилдаа байнга мөрдөж ажиллана. | Оффис хэрэглээний болон ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай бусад программыг гүнзгийрүүлэн судлан ажиллаж байна.<br>- Ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай хууль, тогтоомж, журмыг ажилдаа байнга мөрдөж ажиллаж байна. | 2024.01.01<br>-<br>2024.12.02 | 100 |

ГУРАВ. НЭМЭЛТ АЖЛЫН ХҮРЭЭНД

| Д/Д | Боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвараа сайжруулах арга хэмжээ | Хүрэх түвшин | Хэрэгжүүлэх ажил | Хүрсэн түвшин биелэлт | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлт хувь |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | | 5 | |
| 1 | Төлөөлөл хэрэгжүүлэх ажлын хүрээнд | Төлөөлөл хэрэгжинэ. | Хариуцсан байгууллагуудын УЗ, ТУЗ-ийн хуралд чиглэл, арга зүйгээр хангах | "Төв цэнгэлдэх хүрээлэн" ХХК-ийн ТУЗ-ийн даргын 2024.07.30-ны өдрийн 02 дугаар тогтоолоор ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар томилогдсон бөгөөд 3 удаагийн хурлыг зохион байгуулан холбогдох тогтоол, шийдвэрийг гаргуулан ажиллалаа. Үүнд:<br>_2 дугаар хуралдаанаар:-2024.09.10_<br>1. Компанийн бүтэц, орон тоо болон цалин, хөлсний дээд хэмжээг батлах тухай<br>2. Компанийн 2024 оны санхүүгийн болон үйл | 2024.01.01<br>-<br>2024.12.02 | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | ажиллагааны төлөвлөгөөг батлах тухай<br>3. Хөдөлмөрийн дотоод журам батлах тухай<br>*3 дугаар хуралдаанаар:-2024.10.16*<br>1. Төв цэнгэлдэх хүрээлэн ХХК-ийн гүйцэтгэх захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийг чөлөөлж, гүйцэтгэх захирлыг томилох асуудлыг хэлэлцэн, АТГ-т ХАСУМ-ыг хянуулах хүсэлт хүргүүлэх тухай<br>*4 дүгээр хуралдаанаар:-2024.11.27*<br>1. "Төв цэнгэлдэх хүрээлэн" ХХК-ийн гүйцэтгэх захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийг чөлөөлж, гүйцэтгэх захирлыг томилох болон бусад.<br>"Олон улсын худалдаа логистикийн төв ХК-ийн ТУЗ-ийн 2024.08.02-ны хуралдааныг зохион байгуулсан. Үүнд:<br>1. ТУЗ-ийн даргыг сонгох тухай<br>2. ТУЗ-ийн нарийн бичгийн даргыг томилох тухай<br>3. Гүйцэтгэх захирлыг чөлөөлж, томилох тухай | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 2 | Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллах | Зөрчил дутагдлыг арилгах | Ажлын хэсэгт ажиллан холбогдох тайланг гаргаж, нэгтгүүлэх | Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн А/408 дугаар тушаалаар томилогдсон 7 гишүүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг нь батлагдсан удирдамжийн дагуу "Үндэсний цэцэрлэгт хүрээлэн" ОНӨТҮГ-ын үйл ажиллагаа, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаа, хөрөнгийн хөдөлгөөн, ашиглалт хамгаалалтад 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 06-ны өдрүүдэд хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:<br>1. Удирдах зөвлөлийн хурлын шийдвэр, хэрэгжилт;<br>2. Хөрөнгө оруулалт, их засвар, засвар үйлчилгээ;<br><br>Дээрх 2 агуулгын хүрээнд шалган, холбогдох тайланг гаргаж, нэгтгүүлэн ажилласан. | 2024.01.01<br>-<br>2024.12.02 | 100 |
| 3 | Дээд газарт нэмэлт судалгаа, тайлан гаргаж өгөх | Удирдлагыг мэдээллээр хангах | Судалгаа, мэдээлэл гаргах | Дараах судалгаа, мэдээллийг гарган дээд байгууллагад хүргүүлэв.<br>1. УЗ, ТУЗ-ийн судалгааг НИТХ-д гарган хүргүүлэв.<br>2. Ногдол ашгийн 2020-2024 оны судалгааг гарган НЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлэв.<br>3. УБХГХХХОДТөслийн хүрээнд нийслэлийн өмчид бүртгэгдсэн хөрөнгийн судалгааг НЗДТ-ын нэгдүгээр орлогчид хүргүүлэв. | 2024.01.01<br>-<br>2024.12.02 | - |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 4 | Бүтэц, орон тоо батлуулах | | | Нийслэлийн Засаг даргын 2024.11.04-ний өдрийн А/1295 дугаар захирамжаар дараах газруудын бүтэц орон тоог шинэчлэн батлуулав.<br>1. Багачуud хүнс ОНӨААТҮГ<br>2. Өсвөр үе хүнс ОНӨААТҮГ | 2024.01.01 - 2024.12.02 | |

ТАЙЛАН ГАРГАСАН:
Өмчийн хяналт, шалгалтын хэлтсийн мэргэжилтэн.................................... Б.Адъяа 2024.12.02
(албан тушаал) (гарын үсэг) (нэр) ( Огноо )